



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 18 өдөр

Дугаар А/501

Номгон

Г Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн Г  
үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.4, Ашигт малтмалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Галуут сумын нутагт уул уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглахтай холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, стандартын хэрэгжилтийг хангаж байгаа эсэхэд хяналт, шалгалт хийх ажлыг 2023 оны 09 дүгээр сарын 18-ны өдрөөс 2023 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн хооронд зохион байгуулсугай.

2.Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3.Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт зохион байгуулсан ажлын үр дүн, цаашид авах арга хэмжээний саналыг 2023 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн дотор аймгийн Засаг даргад танилцуулахыг Ажлын хэсгийн ахлагч (Т.Хишигбаатар)-т үүрэг болгосугай.


4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхжаргал)-д даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН



2023.09.18

642311293



АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧДИЙН ҮЙЛ  
АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ АЖЛЫН  
ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: Т.Хишигбаатар – Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга

Гишүүд: Ц.Болорчимэг – Аймгийн Засаг даргын Тамгын газрын Геологи уул  
уурхайн хяналтын Улсын байцаагч

Т.Мөнхжаргал – Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Байгаль орчны  
хяналтын Улсын байцаагч

Нарийн бичиг - Б.Намуун – Аймгийн Засаг даргын Тамгын газрын Байгаль  
орчин, аялал жуулчлал, газрын харилцаа, уул уурхайн бодлого хариуцсан  
мэргэжилтэн

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_